



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

“Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах” зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4, “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Шүүхийн тамгын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, 4 нэрийн, нийт 71,901,652.00 (далан нэгэн сая есөн зуун нэг мянга зургаан зуун тавин хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга болон харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаа худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зар мэдээний зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 4 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001096
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
300 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ХАРЬЯА ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ НЭЭЛТТЭЙ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Автомашины нэр, арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ /Хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	ТӨБЗГ-н 2023 оны 603 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	MITSUBISHI PAJERO	05-87 УНҮ	14,100,000.00	4,000,000.00	3,000,000.00
2	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	Соната-6NF	01-92 УНП	21,700,000.00	2,500,000.00	2,000,000.00
3	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	Истана	50-70 УБС	17,101,652.00	2,500,000.00	2,000,000.00
4	Орхон аймаг дахь Шүүхийн тамгын газар	Тоёота Вероса	00-06 ОРА	19,000,000.00	3,500,000.00	3,000,000.00
Нийт дүн				71,901,652.00	12,500,000.00	10,000,000.00
				(далан нэгэн сая есөн зуун нэг мянга зургаан зуун тавин хоёр)	(арван хоёр сая таван зуун мянга)	(арван сая)